/НЗД-ын 2018 оны А/227 дугаар захирамжаар хүчингүй болсон/

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2004 оны 6 дугаар

сарын 11-ний өдөр Дугаар 287

Улаанбаатар хот

ИРГЭДЭЭС САНАЛ ХҮСЭЛТ, ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙГ

ТЕЛЕФОН УТСААР ХҮЛЭЭЖ АВАХ ҮЙЛЧИЛГЭЭ АЖИЛЛУУЛАХ

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 6.4, 17 дугаар зүйлд заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, албан хаагчдаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хөнгөн шуурхай байдлыг сайжруулах, түүнд оршиж байгаа хүнд суртлыг багасгах зорилгоор иргэдээс санал хүсэлт, гомдол мэдээллийг телефон утсаар хүлээж авах үйлчилгээг 2004 оны 6 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.

Хоёр. Иргэдээс санал хүсэлт, гомдол мэдээллийг телефон утсаар хүлээж авах үйлчилгээ ажиллуулах журмыг хавсралт ёсоор батлсугай.

Гурав. Энэхүү захирамжийг нийт ажилтнууддаа танилцуулахыг нутгийн захиргааны бүх байгууллагуудын удирдлагуудад, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/ -т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА М.ЭНХБОЛД